

ӨВӨР МОНГОЛЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН СУРГАН ХҮМҮҮЖЛИЙН
ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ ХИЙГЭЭД ОДООНЫ БАЙДАЛ

Оюун*

* Өвөрмонголын их сургуулийн профессор

Хөрвүүлсэн: Л.Норовсүрэн.

Түлхүүр үг: Өвөр Монгол, хэвлэл мэдээлэл, сурган хүмүүжил, түүхэн явц, одоогийн байдал.

Нэг. Өвөр Монголын хэвлэл мэдээллийн сурган хүмүүжлийн хөгжилтийн түүхэн явц

XX зууны дөчөөд оны эцсээр Өвөр Монголын өдрийн сонины хороо тухайлсан ажилтадын онолын хэр хэмжээ ба ажлын чадварыг дээшлүүлэхийн төлөө хүмүүжүүлэн боловсруулах анги эрхэлж Юн пү, Жиү фү Чен хай зеү зувен хүн, Чингэлтэй нараар сонин мэдэллийн онолын тухай хичээл оруулж байв. «Өвөр Монголын өдрийн сонины хорооны хүмүүжүүлэн боловсруулах анги нь заримдаа бас бусад сонины хорооны залуу найруулагч, сурвалжлагчийг оролцуулж байлаа. Тухайн үеийн онцгой байдал дор Өвөр Монголын өдрийн сонины хороо хэрэг

дээрээ Өвөр Монгол орны сонин мэдээллийн кадрыг хүмүүжүүлэх төв болж байв.

Өвөр Монголын хэвлэл мэдээллийн сургуулийн сургах хүмүүжлэг бол 1953 онд байгуулагдсан Өвөр Монголын монгол хэлбичгийн тусгай мэргэжлийн сургууль (Одоогийн Өвөр Монголын үндэсний дээд зэргийн тусгай мэргэжлийн сургууль)-ийн тус жилд элссэн найруулах ангиас эхэллээ гэж үзэж болно. Тус сургууль байгуулагдсан тэр өдрөөсөө эхэлж монгол хэлээр ажиллах орчуулагч, найруулагч ба сурвалжлагчийг хүмүүжүүлэх тодорхой харалттайгаар маш олон чадвартныг хүмүүжүүлсэнээс Өвөр Монголын жич Лионин, Хармерен, Шинжаан, Ганьсу, Хөхнуур, Бээжин зэрэг муж, хотын монгол хэлний хэвлэл мэдээллийн үйлсийн хөгжилд баларшгүй хувь зүтгэл үзүүлжээ.

1975 онд Өвөр Монголын их сургуулийн монгол хэл-утга зохиолын салбар сонин мэдээллийн анги эрхэлж,

ерөнхий их сургуулийн хэвлэл мэдээллийн сурган хүмүүжлийн хөшгийг ярсан байна. Бид Өвөр Монголын сурган хүмүүжлийг 1953 оноос эхэллээ гэж үзэхэд хүрвэл эдүгээ нэгэнт 52 жилийн хөгжлийн түүхтэй болж буй. Энэхүү 52 жилийн хөгжлийн түүхэн явцыг их төлөв таван адил бус хөгжлийн шат үе болгон хувааж болно.

1. Эхлэлт хийгээд сүвэгчлэлийн шат үе (1953-1965 он болтол). 1953 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Өвөр Монголын монгол хэлбичгийн тусгай мэргэжлийн сургууль байгуулагдав. Сургуульдаа (эн), (э) хоёр анги хувааж, эн анги нь монголоор орчуулах ажилтныг хүмүүжүүлэх бөгөөд Э анги нь монголоор найруулах ажилтныг хүмүүжүүлнэ. Энэ нь Өвөр Монголын хэвлэл мэдээллийн сурган хүмүүжлийн ажилтан болно. Тухайн үед Төгс, Эрдэнэтогтох зэрэг хүмүүс захирлаар томилогдон Чингэлтэй, Чойжинжав, На.Сайнцогт зэрэг эрдэмтдээр хичээл хүмүүжлийн ажлыг эрхлүүлж байсан юм.

1959 оны 10 дугаар сараас 1962 оны 9 дүгээр сар хүртэл Өвөр Монголын намын хорооны ухуулах хэлтэс хийгээд Өвөр Монголын намын сургууль хамтарч аймаг, хотоос дээших сонин мэдээллийн байгууллага, нэгжээс ирсэн найруулагч, сурвалжлагчаар бүрэлдсэн сонин мэдээллийн ангийг хоёр хугацаа эрхэлжээ. Хугацаа бүрийн цаг нь нэг жил хагас орчим (тухайн үесийн сонины хорооны ерөнхий найруулагч, ахмад сонинч жич намын хорооны ухуулах хэлт-

сийн даргыг залж багшлуулж онолын хичээлийг намын сургуулийн онолын заан судлах тасгийн багш нар эрхлэв.

1960 онд Өвөр Монголын радио нэвтрүүлгийн сургууль байгуулагдав. Тус сургууль бол байгалийн шинжлэх ухааны дунд зэргийн тусгай мэргэжлийн сургууль байж, радио телевизийн мэргэжил техникийн чадвартныг хүмүүжүүлэхээр гол гаралт болгож байв. Энэ үеийн Өвөр Монголын хэвлэл мэдээллийн сурган хүмүүжлийн хичээл хүмүүжлийн онцлог бол: 1. Уулын Зөвлөлт холбоот улсын хэвлэл мэдээллийн сурган хүмүүжлийн загварыг шилжүүлэн хэрэглэсэн, 2. Хөдөлмөрийг жинхэнэ хичээл ёсоор заан сургах төлөвлөгөөнд оруулсан, 3. Улс төрийн хичээлээр голдлого болгож, мэргэжлийн хичээл системчилж дийлэхгүй байв.

2. Бүдрэлд учирсан шат үе (1966-1971 он болтол). Энэ хугацаанд сурган хүмүүжлийн ажил Соёлын их хувьсгалд талхигдагдаж, заан сургах ажил зогсоод 6 жил дараалан сурагч элссэнгүй.

3. Сэргэлтийн шат үе (1972-1985 он болтол) Уулын Өвөр Монголын монгол хэлбичгийн тусгай мэргэжлийн сургууль 1972 оноос сурагч элсэх ажлаа сэргээж, нийгмийн хэрэгцээ шаардлагыг үндэслэж 1979 оноос «Сонин мэдээллийн тусгай сэдвийн хичээл»-ийг нээж, сурагчдын тухайлсан ажил ба нийгэмтэй зохицох чадварыг дээшлүүлэхээр зорьсон байна.

1975 онд Өвөр Монголын их сургуулийн монгол хэл-утга зохиолын

салбар, монголоор хичээллэх сонин мэдээллийн тусгай мэргэжлийн 34 нэрс ажилчин тариачин цэрэг сурагч элсэв. 1985 онд Өвөр Монголын телевиз их сургууль бүх орны 9 салбар сургуульд сонин мэдээллийн мэргэжил гаргав.

Тус хугацаан дахь Өвөр Монголын хэвлэл мэдээллийн сурган хүмүүжлийн хичээл хүмүүжлийн онцлог бол: 1. Үйлдвэрлэл хөдөлмөрт оролцох явдлыг тэргүүн байранд талбиж, хөдөлмөрийн үзэлтийг буй болгохыг зорьсон, 2. Онолыг үйлдлэгтэй уялдуулахыг анхааралдаа авсан, 3. Сонин мэдээний зохион бичлэг ба найруулах ур мэргэжлийг дээшлүүлэх дээр хүч талбиж, хэр тэнцсэн сурвалжлагч, найруулагчийг хүмүүжүүлэхээр гол зорилтоо болгосон.

4. Анхдугаар хөгжилтийн шат үе (1986-1998 он болтол). 1986 онд Өвөр Монголын их сургуулийн сурган хүмүүжлийн яамны зөвшөөрлөөр сонин мэдээллийн мэргэжлийг хятад хэл утга зохиолын салбар ба монгол хэл-утга зохиолын салбарт тус тус гаргаж, 1987 он ба 1988 оноос оюутан элсэж монголын хэвлэл мэдээллийн сурган хүмүүжлийн үндсэн ангийн хөшгийг нээжээ.

1989 оны 1 дүгээр сарын 7-ны өдөр уулын Өвөр Монголын монгол хэлбичгийн тусгай мэргэжлийн сургуульд Өвөр Монгол орон дахь анхдагч сонин мэдээллийн ухааны салбар байгуулагдав. 1993 он ба 1996 онд Өвөр Монголын сонин мэдээллийн мэргэжлийн өөрснөө сурч шалгагдах тусгай мэргэжлийн ба үндсэн ангийн шалгалт тус бүр явагдав. 12 жилийн турш сонин мэдээллийн мэргэжлийн сурагчдыг нийт 6270 (Үүнд тусгай мэргэжлийн сурагч 3778, үндсэн ангийн сурагч 2492) хүмүүжүүлэв. Тус хугацаан дахь хэвлэл мэдээллийн сурган хүмүүжлийн хичээл хүмүүжлийн онцлог бол: 1. Сонин мэдээллийн ухааны онол, түүх

«

Тус хугацаан дахь Өвөр Монголын хэвлэл мэдээллийн сурган хүмүүжлийн хичээл хүмүүжлийн онцлог бол: 1. Үйлдвэрлэл хөдөлмөрт оролцох явдлыг тэргүүн байранд талбиж, хөдөлмөрийн үзэлтийг буй болгохыг зорьсон, 2. Онолыг үйлдлэгтэй уялдуулахыг анхааралдаа авсан, 3. Сонин мэдээний зохион бичлэг ба найруулах ур мэргэжлийг дээшлүүлэхийг зорилтоо болгосон юм.

»

тухайлсан ажлын гурван бүрэлдэхүүн хэсгийн хичээл хүмүүжлийг хүндэтгэх болсон, 2. Онолыг үйлдлэгтэй уялдуулах заан сургах зарчмыг баримтлах болов.

5. Хоёр дахь хөгжилтийн шат үе (1999 оноос одоо хүртэл). 1999 онд Өвөр Монголын их сургуулийн монгол судлалын дээд сургуульд сонин мэдээлэл, хэвлэлийн ухааны салбар байгуулагдав. Энэ нь Өвөр Монголын хэвлэл мэдээллийн сурган хүмүүжлийн түүхэн дэх үндсэн ангийн оюутан хүмүүжүүлдэг анхны салбар болно. Тус

жил сонин мэдээллийн ухааны мэргэжлийн суурин дээр найруулах хэвлэлийн ухааны мэргэжлийг нэмэн эрхэлсэн бөгөөд 2002 онд нэвтрүүлэгч хөтлөгчийн урлагийн мэргэжил гаргаж, дараа жилээс нь оюутан хүмүүжүүлж эхэлжээ. 2003 онд сонин мэдээллийн ухааны мастер цаг гаргаж 5 аспирант элсчээ.

2000 онд Бор тохой их сургууль, 2001 онд Хөлөнбуйр дээд сургууль сонин мэдээллийн мэргэжил гаргаж оюутан хүмүүжүүлэв. 2002 оноос Өвөр Монголын багшийн их сургууль, Өвөр Монголын үндэсний их сургууль, Бугатын багшийн мэргэжлийн сургууль урьд хожид сонин мэдээлэл буюу найруулах хэвлэлийн ухааны мэргэжил гаргаж оюутан элсчээ. Тус хугацаан дахь хичээл хүмүүжлийн онцлог бол: 1. Хичээл хүмүүжлийн хүрээ цараа өргөжиж, хэвлэл мэдээллийн ухааны хичээл төрөл, тооны талаар нэмэгдсэнээр барахгүй агуулгын талаар ч тэлсэн, 2. Хичээлийн тохируулалт дээр үндэстний үзлэгээр ил тод хичээл төрөл нэмэгдсэн, 3. Чадвартныг хүмүүжүүлэх загвар тусгай мэргэжлийн сурган хүмүүжлийн загвараас хэв чанарын сурган хүмүүжлийн загварт шилжсэн.

Хоёр. Өвөр Монголын хэвлэл мэдээллийн сурган хүмүүжлийн хүмүүжлийн одооны байдал

Өвөр Монголын хэвлэл мэдээллийн сурган хүмүүжлийн онцлогийг доорх хэдэн талаар хураангуйлж болно.

1. Хэвлэл мэдээллийн ухааны мэргэжлийн цаг харьцангуйгаар нэмэгдсэн. XX зууны наяд оноос хойш Өвөр Монголын хэвлэл мэдээллийн сурган хүмүүжил нэлээд түргэн хөгжжээ. Одоохонд хэвлэл мэдээллийн ухааны тусгай мэргэжил эрхэлж байгаа энгийн дээд сургууль 7 байж, мэргэжлийн цаг 15 болов. Бүх орны хэвлэл мэдээллийн ухааны мэргэжлийн багш 105, сургуульд суралцаж байгаа аспирант, үндсэн ангийн оюутад ба тусгай мэргэжлийн оюутад 2577 буй. Өвөр Монголын хэвлэл мэдээллийн сурган хүмүүжил одоохонд бүхэл өдрөөр хичээллэх дүрэмт аспирант, үндсэн анги, тусгай мэргэжлийн оюутныг хүмүүжүүлж байхаар барахгүй бас насанд хүрэгчдийн захидлаар сурах сурагч ба өөрснөө сурч шалгуулах сурагчийг ч хүмүүжүүлж буй.

2. Чадвартныг хүмүүжүүлэх систем бүрэлдсэн. Өвөр Монголын хэвлэл мэдээллийн сурган хүмүүжил нь өнгөрсний дан цулгай сонин мэдээллийн мэргэжил буюу найруулах мэргэжлээсээ одоохонд сонин мэдээллийн ухаан, радио телевиз сонин мэдээлэл, найруулах хэвлэлийн ухаан, нэвтрүүлэгч хөтлөгчийн урлаг гэх олон мэргэжил болж хөгжсөн байна. Энэ нь хэвлэл мэдээллийн сурган хүмүүжлийн замыг өргөтгөж, амьжралын хүчнийг нэмэгдүүлжээ. Байгууламжийн талаас ажиглавал зарим сургууль бие даасан салбар гаргаж (Өвөр Монголын үндэсний дээд зэргийн тусгай мэргэжлийн сургууль), зарим сургууль нь бусад

шинжилгээний сапаатай хамтруулж дээд сургууль болгон эрхэлж (Өвөр Монголын их сургууль), зарим нь хэл-утга зохиол мэтийн нийгмийн шинжлэх ухааны салбарт тусгай мэргэжил болгон эрхэлж буй (Хөлөнбуйр дээд сургууль).

Байгууламжийн талаарх эдгээр хэлбэрээс Өвөр Монголын хэвлэл мэдээллийн сурган хүмүүжил амьдлигаар эрхлэгдэж, нэлээд хэмжээгээр хөгжиж байгааг олж харах болно. Төрөл зүйлээр нь үзвэл Өвөр Монголын хэвлэл мэдээллийн сурган хүмүүжлийг ерөнхийлсэн их сургууль ба тусгай мэргэжлийн сургуульд гаргаж байгаагаар барахгүй бас багшийн сургуульд ч эрхэлж буй. Энгийн дээд сургуульд эрхэлж байх мөртөө дунд зэргийн сургууль (Өвөр Монголын радио телевиз сургууль) ч хэвлэл мэдээллийн талын чадвартныг хүмүүжүүлж буй.

Дэс давхаргаас нь шинжвэл Өвөр Монголын хэвлэл мэдээллийн сурган хүмүүжилд нэгэнт аспирант, үндсэн ангийн оюутан, дээд зэргийн тусгай мэргэжлийн оюутан ба дунд зэргийн тусгай мэргэжлийн сурагч зэрэг олон дэсийн чадвартныг хүмүүжүүлэх систем бүрэлдсэн байна.

3. Хичээл хүмүүжлийн чанар чансааны байдал. XX зууны ерээд оноос хойш, их сургуульд шалгагсадын дотор хэвлэл мэдээллийн мэргэжлийг сонгогчид олшров. Үүний улмаас зарим сургууль багшийн эгнээ ба тоног төхөөрөмж зэрэг үндсэн нөхцөл бүрэлдээгүй байдал дор хэвлэл мэдээллийн мэргэжил гаргаж

оюутан элсч, үндсэн мэргэжлийн хичээлийг ч нээж дийлэхгүй байдалд орж, нэг хоёр мэргэжлийн багш бүхий л хэвлэл мэдээллийн сурган хүмүүжлийн бүх талаар дагаагчлан авч оюутан хүмүүжүүлжээ. Хэвлэл мэдээллийн ухаан бол хэрэглээний шинжээр маш чанга нийгмийн шинжлэх ухаан мөн. Энэхүү шинжилгээ нь гүн ухаан, утга зохиол, түүхийн шинжлэх ухаантай маш ялгаатай байж, ерөөсөө одоохчилсон шинжлэх ухаан-техник мэргэжлийн хэрэглэлттэй нягт холбогддог. Хэвлэл мэдээллийн сурган хүмүүжлийг эрхлэх өөрийн өртөг бол тун өндөр, нөгөө талаар (их сургуулийн хөгжилтийг нөлөөлөх элементийн дотор багш бол хамгийн зангилааны элемент мөн.

Багшийн эгнээний тоо ба бүтэц зохисгүй юм бол сурган хүмүүжлийн чанар чансааг батлана гэдгийг хэлэхийн хэрэг алга. Одоохонд хэвлэл мэдээллийн сурган хүмүүжил эрхэлж байгаа эл дээд сургуулиуд багшийн эгнээний бүтээн байгуулалт ба заан сургах тоног төхөөрөмжөөр туршилтын тасгийн бүтээн байгуулалтыг чухалчлан чангатгаж буй. Гэвч бодит нөхцлийн хязгаарлалаас болж багшийн эгнээний бүтээн байгуулалт ба туршилтын тасгийн бүтээн байгуулалт дээр эл сургуулиуд харилцан зөрөөтэй учраас хичээл хүмүүжлийн чанар чансааны талаар харилцан тэгшгүй байдал гарч буй. Эл сургуулиудын тоног төхөөрөмж ба туршилтын тасгийн бүтээн байгуулалтаар багшийн эгнээний бүтээн байгуулалтын одоохоны байдал

нь хэвлэл мэдээллийн сурган хүмүүжлийг эрхлэх нөхцөл ба шаардлагад хүрээгүй байхыг олж харах болно.

4. Ажлын байрны байдал. Хэвлэл мэдээллийн ухаанд харьяалагдах дөрвөн үндсэн мэргэжил-сонин мэдэллийн ухаан, найруулах хэвлэлийн ухаан, радио телевиз сонин мэдээлэл, зарын ухаан бол голдуу мэдээллийн хэрэгслүүдэд чадвартныг хүмүүжүүлэхээр зорилтоо болгодог. Сонины хороо, радио телевиз хороо, хэвлэлийн хороо, кино компани, нам засгийн ухуулах хэлтэс аж ахуйллуудын ухуулгын салаа мөчир, зар компани, жич дээд сургуулийн хэвлэл мэдээллийн салбар ба мэргэжлүүдийн хөгжил ба чадвартныг хэрэгсэх хэрэгцээ шаардлага нь онолын талаар хэвлэл мэдээллийн мэргэжил төгсөгсдийн ажил олох зам өргөн болохыг тогтоосон байна. Гэвч Өвөр Монголын хэвлэл мэдээллийн мэргэжил төгсөгсөдийн хуваарилалтын байдал төдий хангамжгүй. Мэдээллийн хэрэгслүүдэд ажил олох норм нэлээд доор, хангалгаа нь хэрэгцээнээсээ хэтэрсэн байдал илэрч буй. Үүнийг Өвөр Монголын их сургуулийн 2001-2004 онд хэвлэл мэдээллийн мэргэжлээс төгссөн оюутдын хуваарилалтын байдал тодорхойлж болно.

2001-2004 он болтол Өвөр Монголын их сургуулийн хэвлэл мэдээллийн мэргэжлээс нийт 294 оюутад төгсчээ. Үүнд мэдээллийн хэрэгслүүдэд ажил болсон 70 хүн 23,8 хувийг эзэлнэ. Бусад байгууллагад ажиллагсад 224 хүн (үүний

дотор аспирант шалгаж орсон 43, дээд сургуульд ажиллагсад 20, аж ахуйлалд 36, ажил үйлсийн нэгжид 38, гадаадад гарагсад 11, өөр нэгжид 76 хүн) 76,2 хувийг эзэлнэ.

Гурав. Дүгнэлт ба сануулга

Өвөр Монголын хэвлэл мэдээллийн сурган хүмүүжлийн 52 жилийн хөгжлийн түүхэн эргэцүүлэл хийгээд одоохоны байдлын задлалтаас олох дүгнэлт ба сануулга гэвэл: 1. 2001 оноос хойших Өвөр Монголын хэвлэл мэдээллийн сурган хүмүүжлийн түргэн хөгжилт нь хэвлэл мэдээллийн байгууллага, нэгжид бачим шаардагдаж байна. Мэргэжлийн чадвартныг хүмүүжүүлж, тулгам хэрэгцээг хангасан нь үнэнтэй. Гэвч хэвлэл мэдээллийн мэргэжлийн цаг өнгөрүү хурдан нэмэгдэж, тоо хэмжээний талаар ахадсан байдалд оров. Учир нь нэг газар орон, нэг хотод хэвлэл мэдээллийн мэргэжлийг хэт олон эрхлэх нь эх баялгийг төвлөрүүлж, хүчээ бузгайруулахад ашиггүй. Сурган хүмүүжлийн холбогдол бүхий салаа мөчирөөс хэвлэл мэдээллийн сурган хүмүүжил эрхлэх хамаг наад захын бармижаа ба нөхцлийг тогтоох, зохистой хязгаарлавал зохино. Нөхцөл шаардлагагүйгээр үргэлжлэн хэвлэл мэдээллийн мэргэжлийг шинээр нээгээд байхад хүртэл сурган хүмүүжлийн жам хуулиас зөрчөөд хожмын уршигийг төсөөлөхөд бэрх болно.

2. Хэвлэл мэдээллийн сурган хүмүүжлийг эрхлэх өөрийн өртөг тун

өндөр юм. Чухал бүхий ном бичиг, компьютер, бичиг материал ба тоног төхөөрөмжийг бүртгэхээс гадна бас олон талын, зүйл бүрийн хэрэгцээт туршилтын тасгийг бүтээн байгуулах чухалтай. Телевиз программыг сурвалжилж, найруулж үйлдэх машинаар үзэхэд ердөө хэдэн арван түмээс хэдэн зуун түмэн

төгрөг, тэрчилэн хэдэн мянган түмэн төгрөг зарцуулна. Эл дээд сургуулийн тоног төхөөрөмж, туршилтын тасгийн бүтээн байгуулалтад зарцуулсан мөнгө төгрөг шаардлагад хараахан хүрээгүй байгаа нь илхэн байна. Ийм байдал дор хэвлэл мэдээллийн сурган хүмүүжлийн чанар чансаа ба үр бүтэмж ихээр буурах нь дамжиггүй. Иймээс хэвлэл

мэдээллийн сурган хүмүүжлийг эрхэлсэн эл дээд сургууль тус мэргэжил дээр илүүхэн мөнгө төгрөг зарцуулж, чухал шаардагдах туршилтын тасаг ба заан сургах тоног төхөөрөмжийг бүртгэх буюу шинжилж, хэвлэл мэдээллийн сурган хүмүүжлийн өөрчлөлтийг ахиулбал зохино.

3. Хэвлэл мэдээллийн сурагсад маш цөөн мөртөө олонх багш нар бодитой ажлын туршлагагүй эмзэг тал

тун товойм оршиж буй. Иймээс багшийн эгнээний бүтцэд даруй түргэн тохируулалт хийх хэрэгтэй. **Нэгд:** сонин мэдээлэл, аж ахуй, хууль цааз, компьютер зэрэг мэргэжил сурсан багшийг оруулан авчирч багшийн эгнээний мэргэжлийн бүтцийг зохистой болгох, **хоёрт:** одоохоны багш нарыг хүмүүжүүлэн боловсруулж, чухал бүхий мэргэжил шүүлж, мэдлэгийн бүтцийг зохистой байлгах, **гуравт:** багш нарыг үргэлж хэвлэл мэдээллийн байгууллага, нэгжид томилж, хэвлэл мэдээллийн бодитой ажлын туршлагыг эзэмшүүлэх хэрэгтэй.

4. Өвөр Монголын хэвлэл мэдээллийн мэргэжил төгсөгсөдийн хуваа

рилалтын байдал тийм сайн биш болохоор доорх хэдэн сануулга гарга. **Нэгд:** оюутан элсэх тоогоо хасч, төрөл зүйлийг олшруулж тоо хэмжээг багасгана. **Хоёрт:** Хичээл хүмүүжлийн дунд суурь мэдлэгийг чангатгаж, нийгмийн шинжлэх ухаан ба байгалийн шинжлэх ухааныг уусган, оюутадын чадварыг дээшлүүлэхийг анхаарна. **Гуравт:** зах дэлгүүрийн хэрэгцээ шаардлагыг цаг тухайд нь ойлгож, программын ухаалаг,

«

2001 оноос хойших Өвөр Монголын хэвлэл мэдээллийн сурган хүмүүжлийн түргэн хөгжилт нь хэвлэл мэдээллийн байгууллага, нэгжид бачим шаардагдаж байна.

Мэргэжлийн чадвартныг хүмүүжүүлж, тулгам хэрэгцээг хангасан нь үнэнтэй. Гэвч хэвлэл мэдээллийн мэргэжлийн цаг өнгөрүүхурдан нэмэгдэж, тоо хэмжээний талаар ахадсан байдалд оров. Учир нь нэг газар орон, нэг хотод хэвлэл мэдээллийн мэргэжлийг хэт олон эрхлэх нь эх баялгийг төвлөрүүлж, хүчээ бузгайруулахад ашиггүй.

»

зарын мэргэжилтэн, эзэгнэн хамааралтын чадвартныг хүмүүжүүлэхэд талбивал зохино.

Резюме

В статье автор затрагивает проблемы профессионального журналистского образова-

ния во Внутренней Монголии. Автор уделяет внимание аспектам развития журналистского образования, анализирует его современное состояние, также учебные планы ВУЗ-ов, на основании которых выдвигает ряд практических рекомендаций..